



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/249

Мөрөн сум

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Ерөнхий Архитекторын ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Бат-Оргил (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Баасанжав (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтыг газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:


Ц.Баасанжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Аймгийн Ерөнхий Архитекторын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, төслийг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлд хянуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010778 Захирамж 2024